

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН 3, 8-Р БАГТ 2 ШИРХЭГ ТОГЛООМЫН
ТАЛБАЙ БАЙГУУЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

**Тендер шалгаруулалт: Сайншанд сумын 3, 8-р багт 2 ширхэг тоглоомын талбай
байгуулах ажил /2*40000,0/**

Гэрээний нэр, дугаар: ОНХС/ХА-01/2020

Сайншанд хот

2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020.03.29

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Сайншанд сумын 3, 8-р багт 2 ширхэг тоглоомын талбай байгуулах ажил /2*40000,0/”-ыг гүйцэтгэх цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн материалыг **2020 оны 04-р сарын 08**-ны өдрийн **08** цаг **30** минутаас өмнө www.tender.gov.mn цахим хуудсаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04-р сарын 08**-ны өдрийн 09 цаг 00 минутад нээнэ.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:
-2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт /БА-8.1/ ажилбарын заалт,
- ЗТХСайдын 2.8.8 ажилбарын заалт бүхий хүчинтэй хугацаа дуусаагүй барилгын тусгай зөвшөөрөлтэй байна.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймаг Сайншанд хот 3-р баг нутгийн удирдлагын

ордон 1 давхар 106 тоот Утас:7052-2224

e-mail:Dornogovi.tender@yahoo.com

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ: ТШӨХ-д заана.
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын

үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТООЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТООЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн [2] жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт ирүүлэх/ 2019 он, 2018 он/ - Сүүлийн [2] туршлагын мэдээлэл 2018 он, 2019 онд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын дундаж өртөг нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байх /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлцсэн актын хуулбар/; - Сүүлийн [2] жилийн Борлуулалтын орлого дундаж дүн: 2018 он, 2019 оны борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байх /борлуулалтын орлогыг цахим системээс дуудаж үзнэ/ <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: -2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт /БА-8.1/ ажилбарын заалт, - ЗТХСайдын 2.8.8 ажилбарын заалт бүхий хүчинтэй хугацаа дуусаагүй барилгын тусгай зөвшөөрөлтэй байна.</p> <p>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар - Оролцогч компанийн танилцуулга - Үнийн санал - Тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар/ гэрээ болон хавсралтын хамт/ - Ажлын зураг, тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсвийн норм үнэлгээгээр тооцно/ - Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлнэ. - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл - Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Татварын газрын тодорхойлолтыг цахим системээс дуудаж үзэх тул өргүй байх шаардлагатай - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл - Машин механизм тоног төхөөрөмжийн судалгааны жагсаалтыг бодит байдлын фото зураг, холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх - Дээрх шаардлагатай тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш авсан байх - Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг

	<p><i>гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</i></p> <ul style="list-style-type: none"> - <i>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргацтай байх шаардлагатай.</i> - <i>ТШӨХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно</i> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. <i>Автогрейдер, Самосвал 10тн, Автоачигч 1м3, Доргиурт индүү 8тн, Доргиурт индүү 16тн, Усны машин 5000л, Гүний доргиур, Талбайн доргиулагч</i></p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>Tender.gov.mn цахим хаягаар</i> Огноо: <i>2020 оны 04 дүгээр сарын 08 –ны өдөр</i> Цаг: <i>08 цаг 30 минут</i></p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>Сайншанд сум, 3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон</i> Давхар болон өрөөний дугаар: <i>1 давхар 106 тоот</i> Огноо: <i>2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр</i> Цаг: <i>09 цаг 00 минут</i></p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Сайншанд сумын 3, 8-р багт 2 ширхэг тоглоомын талбай байгуулах ажил /2*40000,0/ Гэрээний нэр, дугаар: ОНХС/ХА-01/2020</i></p>

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сайншанд сумын 3, 8 дугаар багт байгуулах хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил:

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг *1 029 000 /Нэг сая хорин есөн мянга/* төгрөгөөр, захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "Ү" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТЯ-ны 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ё. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Ж. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

1. Талбайн газар шорооны ажил

Барилгын газар шороо, буурь суурийн ажлыг гүйцэтгэхэд БНБД 3.02.01-90-г баримтална.

Талбай хийх газрыг нэлэнхүйд нь жигдлэн түрж тэгшлэх, сул шороог индүүгээр нягтруулах шаардлагатай. Гадаргуун тэгшилгээ, нягтруулалтыг бүрэн хийсний дараа дараагийн үе шатны ажлыг эхлүүлнэ.

2. Сагсны талбай

Тэгшилсэн гадаргууд хайргаар нягтруулалт хийж дэвсгэр үе хийнэ. Сагсны талбайг 10см-ийн зузаан БМ100 маркийн бетоноор цутгаж хийнэ. Цутгалт авахын өмнө болон дараа нь бетоны арчилгааг сайтар хийж пленк дэвсэх, хучих, хэв гажилтын заадал гаргах зэрэг ажлуудыг технологийн дагуу гүйцэтгэнэ. Талбайд буусан бороо цасны усыг зайлуулахын тулд цутгалт хийхдээ бага зэргийн хэвгий гаргаж өгнө.

Бетоны гадаргууг жигд өнгөлж, хөрсжүүлэгч түрхсэний дараа зориулалтын будгаар өнгө ялгаж 2 үе стандартын дагуу будна.

3. Сагсны талбайн төмөр торон хашааны ажил

Сагсан бөмбөгийн талбайн хашааны өндөр 3м-тэй байх ба хашааны шонг БМ100 маркын бетоноор хамгийн багадаа 80см-ын гүнд цутгаж суурилуулна. Бага насны хүүхдүүд

хашааруу авирч торыг гагнаасаар нь салгах, салхины үйлчлэл ихтэй тул хашаа ханарч нурах асуудал их гардаг тул торыг их рамтай нь бэхэлж полсвой төмрөөр бүслүүрдэн гагнах болон хашааны хөшүүн чанарыг сайтар хангах шаардлагатай.

4. Хүүхдийн тоглоомын талбай

Явган замын хавтанг угсрахдаа элс цементэн багсармал дээр дэвсэж, хавтан хоорондох зайг мөн багсармалаар гагнаж, суларч ховхорхооргүй сайтар бөхлөх шаардлагатай. Чийрэгжүүлэх дасгалын төхөөрөмж, хүүхдийн тоглоом, турник зэргийг суурилуулахдаа 60-80см-ын гүнд М100 маркийн бетон цутгаж хөдөлгөөнгүй, угзралтад тэсвэртэйгээр байршуулахыг анхаар.

5. Хүүхдийн тоглоомын талбайд төмөр хайс, турник угсрах

Тоглоомын талбайг 60см-ын өндөртэй төмөр сараалжин хайсаар хашаалах бөгөөд газрын хэвгийнээс хамаараад талбай борооны усанд автахаар бол зураг өсөвт тусгагдсан шон суурийн оронд хашааг шугаман сууринд бэхэлж өгөх нь зүйтэй.

Төмөр хашааг өнгөний шийдэл гарган олон өнгийн будгаар алаглуулж эсвэл зураглал хэлбэрээр 2 үе тосон будгаар будна.

6. Гэрэлтүүлгийн ажил

Цахилгаан монтажийн угсралтын ажлыг гүйцэтгэх үед БНБД 3.05.06-90-г мөрдлөг болгоно.

Тоглоомын талбайд 6м-ийн өндөртэй 1 толгойтой 12 ширхэг лед гэрэлтүүлгийг угсарч, гэрэлтүүлэгчийн шонг зурагт заагдсан хэмжээтэй сууринд анкерлаж сайтар бөхлөх. Суурийг БМ150 маркийн бетоноор цутгаж хийнэ. Мөн цагийн реле, электрон тоолуур, зэргийг угсарч байрлуулна.

7. Сүүдрэвч

Сүүдрэвч хийх модон эдлэлүүдийг сайтар харуудаж, зүлгүүрээр өнгөлсний дараа 2 үе тосон будгаар будна. Сүүдрэвчний дээврийг OSB хавтангаар хийх ба хавангийн дээд талд шинглас хар цаас нааж, доод талыг ус чийгнээс хамгаалж 2 үе тосон будгаар будна.

8. Талбай дасгалын төхөөрөмж, тоглоом суурилуулах

Сагсан бөмбөгийн талбай нь 2 талдаа шийдтэй стандарт хэмжээ бүхий талбай байх бөгөөд тухайн баг хорооны иргэд болон, зохион байгуулалттай тоглолт хийхэд тохиромжтойгоор шүүгч, тоглогчид, үзэгчид суух талбайд сандал байрлуулна. Төсөвт өгөгдсөн тоо хэмжээний дагуу тоног төхөөрөмж, тоглоомуудыг төслийн байранд байршуулна. Дасгалын төхөөрөмж, гулсуур, савлуур зэргийг худалдан авахдаа найдвартай, бат бөх, төмөр сайтайг нь сонгох нь зүйтэй.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Талбайн угсралтын ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.

2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
4. Барилгын талбайд хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
5. Талбайн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
6. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

А Ж Л Ы Н Т О О Х Э М Ж Э Э

2020/03/14

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
01. Талбайн газар шорооны ажил			
1	Талбайг бульдозероор тэгшлэх	м2	1,252.20
2	Бульдозероор шороог түрэх	м3	357.66
3	5.6тн -моторт индүүгээр талбайн шороог нягтруулах	м2	1,252.20
02. Сагсны талбайн ажил			
4	Хөрсийг хайргаар нягтруулж дэвсгэр үе хийх	м3	21.20
5	Бетон дэвсгэр үе хийж өнгөлөх БМ-150 6-10см	м3	42.40
6	Бетон гадаргууд цавуун хөрсжүүлэлт үе хийх	м2	424.08
7	Талбай өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м2	424.08
03. Сагсны талбайн төмөр торон хашааны ажил			
8	Сагсны талбайн 3 өндөртэй төмөр шонтой төмөр торон хашааг суурийн бетоны хамт угсрах	м	118.00
9	Төмөр шонтой жижиг хаалга	ш	4.00
10	Төмөр хийцийн бэлдэц бэлтгэх	тн	3.90
11	Хашааны төмөр шонг өнгийн сурик будгаар 2 удаа будах	тн	3.90
12	Шонгийн нүх гараар ухах	м3	12.60
13	Бетон суурь цутгах М100	м3	6.40
14	Шонгийн нүх хайрган хөрсөөр эргүүлж булах	м3	6.20
04. Хүүхдийн тоглоомын талбай			
15	Явган замын доор элс цементний багсармал дэвсгэр үе хийх	м3	11.86
16	Явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийх /1м2 талбайд орох хавтангийн тоо 16-50ш/	100м2	1.18
17	Явган замын хашлага тавих	100у/м	2.20
18	Элсэн талбайд бетон хашлага цутгах М100	м3	7.56
19	Элсэн талбай хийх б=35 см	м3	10.60
20	дасталын төхөөрөмж, хүүхдийн тоглоомын бетон суурь цутгах М№100	м3	3.00
05. Хүүхдийн тоглоомын талбайд төмөр хайс, турник угсрах			
21	Хогийн сав суулгах	ш	4.00
22	Төмөр турник угсрах	ш	4.00
23	Төмөр хийцийн бэлдэц бэлтгэх	тн	0.28
24	Төмөр хийц тосон будгаар 2 удаа будах	тн	0.28
25	0.6 м өндөртэй төмөр шонтой төмөр сараалжин хашаа	м	102.00

Сайншанд сумын 3, 8 дугаар багт байгуулах хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
26	Төмөр хийцийн бэлдэц бэлтгэх		0.86
27	Төмөр сараалжин хайс тосон будгаар 2 удаа будах	тн	0.86
28	Труник суулгах нүх, сараалжин хашааны шонгийн нүх гараар ухах	м3	5.20
29	Нүхэнд бетон цутгах БМ100	м3	3.50
30	Нүх шороогоор эргүүлж булах	м3	1.70
06. Сүүдрэвч			
31	Дүнзэн дан тулгуур, холбоос ба дам нуруу угсрах	м3	0.60
32	Банзан шувуу нуруу угсрах	м3	0.80
33	Цэвэр банзан карниз угсрах	м2	3.42
34	Элементүүдийг харуулдах	м3	1.54
35	Модон хийц өнгийн тосон будгаар гар аргаар сайн чанартай будах	м2	67.80
36	Сүүдрэвчний дээврийг OSB хавтангаар бүрэх	м2	19.60
37	Сүүдрэвчний дээвэрт шинглас хар цаас, ам даралтны хамт нааж хадах	м2	25.60
07. Талбай дасгалын төхөөрөмж, тоглоом суурилуулах			
38	Сагсны шиг суурилуулах	ком	2.00
39	2 тал руугаа гулсаг сайн чанарын гулсуур суурилуулах	ком	2.00
40	Дүүжин савлуур суурилуулах	ш	2.00
41	Дасгалын төхөөрөмж угсрах /хөлний савлуур/	ком	4.00
42	Дасгалын төхөөрөмж угсрах /гарны диск/	ком	2.00
43	Дасгалын төхөөрөмж угсрах /дугуй/	ком	2.00
44	Дасгалын төхөөрөмж угсрах нурууны таталт/	ком	2.00
08. Талбайн гэрэлтүүлэг			
45	Шонгийн нүх, кабелийн шуудуу гараар ухах	м3	46.40
46	Гадна талбайн I толгойтой төмөр шонгой лед гэрэлтүүлэгч угсрах h- 6 м	ш	12.00
47	Цагийн хугацааны реле угсрах	шир	2.00
48	Электрон тоолуур угсрах	ш	2.00
49	Шонгийн суурь цутгах БМ150	м3	1.92
50	Тэжээлийн кабелийг шуудуунд угсрах	м	200.00
51	16мм хүртэл голчтой хуванцар хоолойг угсрах	м	240.00
52	Кабель сүвлэх 50мм хүртэл голчтой хуванцар хоолойг угсрах	м	200.00
53	Шонгийн нүх, кабелийн шуудуу гараар эргүүлж булах	м3	44.08
99. Хог хаягдлын дүн			
54	Хог хаягдал	тн	0.00

Сайтшианд сүмийн 3, 8 дугаар багт байгуулах хуухдийн тоглоомын талбайн тохиожилтын ажил

ЖИШИГ МАЯГТ
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгааар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгааар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

7. **Ажлын хөтөлбөр** 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- 9. Зөрчил, гологдол арилгах** 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

тооцоо

төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг

аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг
цуцалсан үед
хийх төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Сайншанд сумын 3, 8-р багт 2 ширхэг тоглоомын талбай байгуулах ажил /2*40000,0/ Гэрээний нэр, дугаар: ОНХС/ХА-01/2020
ГЕН 2.1	Ажил нь: / : Сайншанд сумын 3, 8-р багт 2 ширхэг тоглоомын талбай байгуулах ажил /2*40000,0/ Гэрээний нэр, дугаар: ОНХС/ХА-01/2020 бүрдэнэ. Ажлын талбай нь :Сайншанд сумын нутаг дэвсгэрт байршина.
ГЕН 3.1	Төслийн менежер нь: ГХБХБГ-ын хяналтын инженер П.Дэлгэрхүү
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр 2020.04.15 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2020.05.01
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [ажлын 5] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа: Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу туршилт тохируулга 12 сар, 14.6-д заасны дагуу хэвийн ашиглалтын хугацаа 36 сар байна. Барилга угсралтын ажилд шаардагдах гол нэр төрлийн материалын дээжийг итгэмжлэгдсэн барилгын материалын сорилт шинжилгээнд хамруулна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [1 хувь] байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10 хувь] байна. Гүйцэтгэлийн зургийг [2020.04.20]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ[500000 төгрөг] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [0 хувь]-иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ	ЗӨВШӨӨРСӨН
_____	_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/_____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/,

_____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]